

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ – ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2021.12.15

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа, хуваарь	Хариуцах нэгж, албан тушаалтан	Хамтран ажиллах байгууллага, албан тушаалтан	Хэрэгжилтийн мэдээлэл, Хэрэгжилтийн хувь
Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх						
1	1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн авлигын эсрэг сурталчилгаа, хууль тогтоомж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах	<ul style="list-style-type: none"> - Сурталчилгаа, мэдээлэл, ухуулан таниулах материал, гарын авлага, зурагт хуудас, хөдөлгөөнт зураг, теле зохиомж, тв шторк, видео график зэргийг боломжтой хэлбэр, олон төрлийн сувгаар нийтэд хүргэсэн байх; - Баримтжуулж, үр дүнг тайлагнасан байх. 	Жилдээ, тухай бүр	Хууль, эрх зүйн хэлтэс (ХЭЗХ), Захиргаа, удирдлагын хэлтэс (ЗУХ)	Хэлтэс, алба	<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн гарын авлага, ном, сэтгүүл, товхимол, судалгааны тайлан, зурагт хуудас гэх мэт материалыг ТӨБЗГ-ын албан хаагчид, тус байгууллагаар үйлчлүүлэхээр ирсэн иргэд, олон нийт, харилцагч, хамтрагч байгууллагын төлөөлөлд сурталчлан таниулах зорилгоор тусгайлан булан ажиллуулж байна. Мэдээллийн самбарын “Авлигын эсрэг” буланд зарим мэдээлэл, сурталчилгаа, холбогдох хууль тогтоомжийг байршуулан сурталчилж байна.</p> <p>Мөн байгууллагын цахим хуудсанд АТГ-ын бэлтгэсэн авлигын эсрэг нөлөөллийн видео сурталчилгаа 2, телезохиомж 3, үндэсний тайлан, судалгааны материал 1-ийг байршуулсан бөгөөд видео сурталчилгаагаар дамжаад интернетийн youtube сувгаар бусад сурталчилгааны видеог үзэх боломжийг бүрдүүлсэн..</p> <p>ТӨБЗГ-ын цахим хуудсыг шинээр хийж байгаатай холбоотой https://pcsp.gov.mn цахим хуудаст өмнөх түүхүүд бүрэн цэгцтэй татагдаагүй байна, байгууллагын албан ёсны</p>

					цахим хуудасны хөгжүүлэлт, шинэчлэлтийн ажил хийгдэж байна. (100 хувь)	
2	1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбарын хэмжээнд зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Дэмжиж хамтран ажилласан байх; - Байгууллага, салбарын хэмжээнд зохион байгуулсан ажлын үр дүнг тайлагнасан байх. 	Жилдээ	ЗУХ, Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтэс (ТӨУЗХ)	Хэлтэс, алба	Авлигатай тэмцэх газрын 110 дугаартай утсыг сурталчлах аяныг байгууллагын хэмжээнд өрнүүлж, албан хаагчдад болон олон нийтэд сурталчлах ажлыг хийсэн. Байгууллагын цахим хуудсанд аяны сурталчилгааг байршуулан авлигын эсрэг олон нийтийн зүгээс мэдээлэх гомдол, мэдээллийг хүлээн авах ажлыг сурталчилсан байна. (100 хувь)
3	1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлэх; - Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх. 	Жилдээ, тухай бүр	ЗУХ	Хэлтэс, алба, Авлигатай тэмцэх газар (АТГ)	“Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг АТГ-аас бэлтгэж, төрийн байгууллагуудад өгсөн боловч ТӨБЗГ-ын мэдээлэлд хүлээлгэж өгөөгүй. ТӨБЗГ-ын байранд ТХААГ, ЖДҮГ, МЭЕГ байрладаг бөгөөд эдгээр байгууллагад уг самбар байгаа. АТГ-аас 2020 онд өгсөн хууль сурталчлах самбарыг байршуулсан. Цахим хуудас, зурагт хуудсаар авлига, ашиг, сонирхлын зөрчил, шударга бус байдалтай холбоотой гомдол, мэдээллийг АТГ-т хүлээн авах “110” дугаартай утсыг сурталчилж ажилласан байна. (100 хувь)

Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах

4	2.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ авах, хэрэгжилтийг хангах	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хэрэгцээг тодорхойлж, захиалгыг АТГ-т хүргүүлсэн байх; - АТГ-ын сургалтад хамрагдсан албан хаагчдын тээ. 	1-2 сард	ЗУХ	Хэлтэс, алба	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах хэрэгцээ шаардлагыг судалж, Авлигатай тэмцэх газрын УССГХ-т сургалтын санал нэгтгэн өгч, АТГ-ын болон ТӨБЗГ-ын сургалтын төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ авсан. АТГ-т саналыг 2 дугаар сард өгч, АТГ-ын хүсэлтээр 5 дугаар сард шинэчлэн тодотгосон. Уг захиалгад ТӨБЗГ-ын 50 албан хаагчийг, төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 40
---	---	---	----------	-----	--------------	---

					<p>хараат бус гишүүнийг авлигын эсрэг сургалтад хамруулах, төрийн өмчит хуулийн этгээдийн захирал, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ы семинарыг тус тус тусгасан. ТӨБЗГ-ын харьяа төрийн өмчит 19 хуулийн этгээдээс ирүүлсэн сургалт, семинарын саналыг нэгтгэж, нийт 473 хүнийг авлигын эсрэг сургалтад, 10 хүнийг сургагч багшийн сургалтад хамруулж, 2 байгууллагад тодорхой сэдвийн хүрээнд семинар хийх талар саналыг мөн АТГ-т хүргүүлсэн.</p> <p>2021.11.09-ний өдөр АТГ-т тайлант жилийн 4 дүгээр улирлын сургалтын захиалга өгч, тсдотгол хийсэн. Үүнд: ТӨБЗГ-ын 9 албан хаагчийг анхан шатны, 18 албан хаагчийг давтан сургалтад хамруулахаар төлөвлөгөөг тсдотгосон боловч Төрийн албаны тусгай шалгалттай давхацсанаар анхан шатны сургалтад хамрагдах албан хаагчдын сургалт цуцлагдсан. Нийт 2 албан хаагчийг АТГ-ын Олон нийтийн төвд давтан сургалтад хамруулаад байна (ЗУХ-ийн дарга, хуулийн мэргэжилтэн). Сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө цар тахлын үеийн нөхцөл байдал, бусад хүчин зүйлээс шалтгаалан бүрэн хэрэгжээгүй.</p> <p>АТГ-аас 2021.12.08-ны өдөр зохион байгуулсан “Авлигын эсрэг үндэсний чуулган”-д ЗУХ, ТӨУЗХ-ийн дарга нарыг хамруулав.</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 2 удаагийн хэлэлцүүлэгт ТӨБЗГ-ын холбогдох албан хаагчид, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын давхардсан тоогоор 40 албан хаагчийг хамруулсан байна. (100 хувь)</p>
--	--	--	--	--	---

5	2.2. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулж, үр дүнг тооцох, тайлагнах	- Сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан албан хаагчдын тоо.	Жилдээ	ЗУХ	Хэлтэс, алба	<p>Тайлант оны 4 болон 5 дугаар сард дараах сэдвийн хүрээнд байгууллагын албан хаагчдад дотоод нөөц бололцоонд тулгуурлан цар тахлын нөхцөлд видео болон PPT танилцуулга хэлбэртэй сургалтын материал бэлтгэж, байгууллагын дотоод сүлжээ, нийгмийн сүлжээн дэх хаалттай бүлгэмд байршуулан хуулийн сургалт, сурталчилгааг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн байгууллага мэдээллийн ил тод байдлаа хэрхэн хангах вэ?; 2. Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтын тухай; 3. Мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалт; 4. Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт. <p>ТӨБЗГ-ын албан хаагчдын дунд Давхар ажил эрхлэлттэй холбоотой хуульд заасан журам, хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлэх талаар хууль сануулах хуудсыг дотоод сүлжээгээр дамжуулан хүргүүлж, Давхар ажил эрхлэлтийн судалгааг авах ажлыг зохион байгуулав. Судалгааны дүнг 2022 оны 1 –р сард байгууллагын удирдлага, албан хаагчдад танилцуулахаар ажиллаж байна.</p> <p>“Гэвь-Алтай АЗЗА” ТӨХК, “Увс АЗЗА” ТӨХК, “Ховд АЗЗА” ТӨХК-ийн эрх бүхий албан тушаалтан 10 хүнийг оролцуулсан “Албан тушаалтанд тавигдах хориглолт” сэдвээр цахим сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулав. (100 хувь)</p>
---	--	--	--------	-----	--------------	--

Зорилт 3. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, мэдээлэх

6	3.1. АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг	- Арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнасан байх	Жилдээ, тухай бүр	Хэлтэс, алба	АТГ, ТӨХЭ	Авлигатай тэмцэх газраас 2021 онд нийт 110 албан бичгийг хүлээн авч, хамтран ажилласан
---	--	---	-------------------	--------------	-----------	--

	хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах					<p>байна. АТГ-аас ирүүлсэн албан бичгийн төрөл, агуулгын хүрээ:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хариу хүргүүлэх, баримт гаргуулах, хүсэлт, санал ирүүлэх, гомдал шилжүүлэх, бусад гэсэн чиглэлээр – 93; 2. Зөвлөмж, чиглэл хүргүүлэх, зөрчилд хариуцлага тооцуулах, зөрчил арилгуулах, мэдэгдэл хүргүүлэх агуулга бүхий чиглэлээр - 17. <p>АТГ-аас бүрэн эрхийнхээ хүрээнд ирүүлсэн хариутай албан бичгүүдийг хууль тогтоомжид заасны дагуу хариу хүргүүлж ажиллав.</p> <p>Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс өгсөн чиглэл, мэдэгдлийн дагуу төрд учруулсан хохиролд тосцсон нийт 175,345.1 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах ажлыг шийдвэрлэн зохион байгуулж, бүртгэн авсан байна. (70 хувь)</p>
7	3.2.Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх	- Арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнасан байх.	Жилдээ, тухай бүр	Хэлтэс, алба	АТГ, ТӨХЭ	<p>АТГ-ын мөрдөгчөөс тайлант хугацаанд нийт 2 мэдэгдэл ирүүлсэн байна. 1 мэдэгдлийн хариуг АТГ-г хүргүүлсэн, нэг мэдэгдлийн хариуг хүргүүлэх хугацаа болзоогүй байгаа бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 22-ны дотор хүргүүлэхээр зохион байгуулалтын арга хэмжээ авч байна.</p> <p>Мөрдөгчийн мэдэгдлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газар болон “Нээлттэй нийгэм форум” ТББ хамтран 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны ил тод байдал” цахим хэлэлцүүлэгт холбогдох албан тушаалтан, байгууллагын оролцоог хангах ажлыг зохион</p>

					байгуулав. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын холбогдох 20 албан тушаалтныг оролцуулсан. Цахим хэлэлцүүлгийн үеэр “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын хийсэн холбогдох судалгааны дүн, дүгнэлт, зөвлөмжтэй танилцан хэлэлцсэн бөгөөд Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ панель хэлэлцүүлэгт тодорхой санал хэлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан ёсны байр суурийг илэрхийлсэн.
					Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ “Монголросцветмет” ТӨҮГ-ын удирдах ажилтнуудыг оролцуулсан нийтлэг гарч байгаа хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах, цаашид давтан гаргуулахгүй байх асуудлаар 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр цахим хэлэлцүүлэг хийж, мэдээлэл, санал солилцсон. (100 хувь)
8	3.3.Зөрчил арилгуулахаар ирүүлсэн албан бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх	- Арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнасан байх	Жилдээ, тухай бүр	Хэлтэс, алба АТ, ТӨХЭ	Авлигатай тэмцэх газраас тайлант хугацаанд бүрэн эрхийнхээ хүрээнд зөрчил арилгуулах талаар нийт 5 мэдэгдэл, чиглэл ирүүлсний 3 нь төрд учирсан хохирол барагдуулж, төрийн өмчид хөрөнгө бүртгэн хүлээж авах асуудлаар, 2 нь худалдан авах ажиллагааны явцад гарч байгаа зөрчлийг арилгуулах чиглэлээр арга хэмжээ авах асуудалтай холбоотой байна. Эдгээрийг шийдвэрлэх арга хэмжээг авч, холбогдох баримт бүхий хариуг АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлэн мэдээлсэн байна.
					Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс өгсөн чиглэл, мэдэгдлийн дагуу төрд

					<p>учруулсан хохиролд тосцсон хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах ажлыг зохион байгуулж ажилласан. Төрийн өмчид нийт дүнгээр 175,345.1 сая төгрөгийн дараах хөрөнгийг хүлээн авсан:</p> <ul style="list-style-type: none"> • МСК ХХК-иас гадаад улсад байгаа 4,475,440,500.00 төгрөгийн үнэ бүхий орон сууцны барилга; • Иргэнээс хохиролд шилжүүлэх хүсэлт гаргасан 269,369,721.00 төгрөгийн үнэлгээ бүхий 105.51 м.кв талбай бүхий нийт 4 өрөө орон сууц. <p>Капитал банкны эрх хүлээн авагчаас Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн эрсдэлд орсон мөнгөн хөрөнгөд тосцон хүлээн авах үл хөдлөх хөрөнгө:</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн даатгалын сангийн эрсдэлд орсон 136.1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн зарим хэсэгт тооцон 67.4 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө; • Нийгмийн даатгалын сангийн эрсдэлд орсон 103.2 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө хүлээн авах. <p>Худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан зөрчлийг арилгуулах, дахин гаргахгүй байх арга хэмжээ авч, холбогдох албан тушаалтанд хариуцлага тосцсон байна. (100 хувь)</p>
--	--	--	--	--	--

Зорилт 4. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл, санаачилга өрнүүлэх

9	4.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас	- Санал, санаачилга, уриалгад нэгдэх арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байх;	Тухай бүр	Хэлтэс, алба	АТГ, Төрийн болон төрийн	Авлигын эсрэг бусад байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриалга, уриа, аянд нэгдэх ажлыг цар тахлын үед өргөн хүрээнд зохион байгуулах болсмжгүй байсан. Гэвч Авлигатай тэмцэх газрын 110 дугаартай утсыг сурталчлах
---	--	--	-----------	--------------	--------------------------	--

	гаргасан санал, санаачилга, уриалга, уриа, аянд нэгдэх	- Бусад байгууллагатай хамтран ажилласан байх.			бус байгууллага	<p>аяныг байгууллагын хэмжээнд өрнүүлж, албан хаагчдад болон олсон нийтэд сурталчлах ажлыг хийсэн. Байгууллагын цахим хуудсанд аяны сурталчилгааг байрлуулан авлигын эсрэг олон нийтийн зүгээс мэдээлэх гомдол, мэдээллийг хүлээн авах ажлыг сурталчилсан байна.</p> <p>Албан хаагчдын дунд Давхар ажил эрхлэлтийн судалгааг явуулж, хууль сурталчлах, мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг холбогдох хуулийн үйлчлэлд хамаарах болон эрсдэлтэй албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдаар гаргуулах, байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийн талаар "Хэрэглэгчийн үнэлгээ" хийх зэрэг ажлуудыг тайлант хугацаанд зохион байгуулахад төрийн өмчит болон төрийн өмчит хуулийн этгээд, төрийн бусад байгууллагатай хамтран ажилласан.</p> <p>ТӨБЗГ нь АТГ-аас 2 жил тутамд зохион байгуулдаг Шударга байдлын үнэлгээнд хамрагдсан. Уг судалгааны ажлын гүйцэтгэгчээр сонгогдон ажилласан "Эс Ай Си Эй" ХХК-ийн судалгааны багтай хамтран ажиллаж, 120 гаруй хүнээс асуумж хэлбэрээр авсан судалгааны ажилд дэмжлэг үзүүлэн, зохион байгуулалтаар ханган ажилласан. (100 хувь)</p>
10	4.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах арга хэмжээ авах	<p>- Гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар холбогдох заалтыг тусгасан байх;</p> <p>- Гэрээний бүртгэл, хяналтыг хэрэгжүүлсэн байх.</p>	Тухай бүр	Хэлтэс, алба	ХЭЗХ, ЗУХ	Төрийн өмчит болох төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал нартай байгуулах контрактанд авлигын эсрэг хууль тогтоомж, удирдлагын ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх, аливаа зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх асуудлаар заалт тусгагдсан бөгөөд контрактыг үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

					<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт бусад байгууллагатай хамтран ажиллах талаар 6 тэрээ хийсэн бөгөөд худалдах, худалдан авах гэрээнд авлигын эсрэг заалт тусган баталгаажуулсан.</p> <p>Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ байгуулах ажлыг хялбаршуулах арга хэмжээ авч, ТӨБЗГ-ын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 02 дугаар тэмдэглэлээр 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цар тахлын үед холбогдох хуулийн дагуу түрээсийн гэрээг хийхдээ түрээслэгчийг сонгон шалгаруулалтгүйгээр шинээр байгуулах, хуучин гэрээг сунгах боломжоор хангах зохицуулалт хийсэн. Ийнхүү төрийн өмчийг түрээслэгч аж ахуйн нэгжүүдэд чирэгдэлгүй, шат дамжлагыг хялбаршуулсан байдлаар үйлчилгээ, дэмжлэг үзүүлж, цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг дэмжин ажилласан байна.</p> <p>2021 онд 756 түрээсийн гэрээний хэрэгжилтийг хангуулан улсын төсөвт төрийн өмчийн түрээсийн орлого болох 2.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэв. (100 хувь)</p>
--	--	--	--	--	--

Зорилт 5. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах

11	5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч, хэрэгжүүлэх /Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах,	<ul style="list-style-type: none"> - Албан хаагчдын давхар ажил эрхлэлтийн судалгааг авч, дүгнэлт, санал боловсруулах, танилцуулах; - Байгууллагын үйл ажиллагааны талаар 	4 дүгээр улиралд	ЗУХ, Мэдээлэл, технологийн алба (МТА)	Хэлтэс, алба	Энэ чиглэлээр албан хаагчдын дунд Давхар ажил эрхлэлтийн судалгааг явуулж, хууль сурталчлах, мэдүүлэг мэдэгдэл тайлбарыг холбогдох хуулийн үйлчлэлд хамаарах болон эрсдэлтэй албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдаар гаргуулах, байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийн талаар "Хэрэглэгчийн үнэлгээ" хийх зэрэг ажлуудыг тайлант хугацаанд зохион байгуулсан. Давхар
----	--	---	------------------	--	--------------	--

	ил тод байдлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны талаар санал асуулга авах, холбогдох үнэлгээ, судалгаанд хамрагдах гэх мэт/	сэтгэл ханамжийн судалгааг авч, дүгнэлт хийх; - АТГ болон бусад байгууллагаас зохион байгуулах үнэлгээ, судалгаанд хамрагдсан байх.			ажил эрхлэлтийн судалгаа, Хэрэглэгчийн үнэлгээний дүн дүгнэлтийг 2022 оны 1-р сард танилцуулахаар бэлтгэж байна. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, мэдээ, мэдээллийг дуурхай дамжуулахад анхаарч ажиллаж байна. ТӨБЗГ мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангахад дстоод албаны цахим сүлжээ, албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээ, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, 2 мэдээллийн самбар зэргийг ашиглаж байна. ТӨБЗГ нь АТГ-аас 2 жил тутамд зохион байгуулдаг Шударга байдлын үнэлгээнд хамрагдсан. 120 гаруй хүнээс асуумж хэлбэрээр авсан судалгааны үнэлгээгээр улсад 5-д, Засгийн газрын агентлагийн дүнгээр 3-т эрэмбэлэгдсэн байна. (100 хувь)
--	---	--	--	--	--

Зорилт 6. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах

12	6.1.Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох заалтаар үүрэг болгосон мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд холбогдох албан ёсны цахим хуудсанд байршуулах	- Хуулийн хугацаанд мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулж хуулийн хэрэгжилтийг хангах.	Жилдээ, тухай бүр	ЗУХ, МТА Хэлтэс, алба	Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох заалтаар хүлээсэн төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийн дагуу байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлэх ажлыг хэвшүүлж ажилласан. ТӨБЗГ-ын чиг үүргээс Төрийн худалдан авах ажиллагааны чиг үүрэг салж, энэ чиглэлээр тусдаа агентлаг шинээр бий болсонтой холбоотойгоор тус байгууллагын албан ёсны цахим хуудсыг шинэчлэх, хөгжүүлэх арга хэмжээг авч ажиллав. ТӨБЗГ-ын https://pcsp.gov.mn цахим хуудсыг шинэчлэх ажил бүрэн дуусаагүй байгаа тул зарим мэдээ мэдээлэл бүрэн орох боломжгүй байдал байна.
----	--	---	-------------------	-------------------------------------	---

						Тодорхой мэдээллүүдийг үе шаттайгаар байршуулж, нээлттэй байдлыг хангаж байна. Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын төсөв, санхүү, худалдан авалттай холбоотой хуульд заасан мэдээллүүдийг тухай бүр оруулж байна. (100 хувь)
13	6.2.Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх	- Байгууллагын үйл ажиллагааг мэдээллийн олон сувгаар сурталчлан мэдээлж, нээлттэй, ил тод байдлыг хангасан байх.	Жилдээ	МТА	Хэлтэс, алба	Тайлант хугацаад ТӨБЗГ-ын газрын бүтэц, орон тсонд шинээр бий болсон хэвлэл мэдээллийн ажилтны сул эрон тоог нөхөж, мэргэжлийн дадлага, туршлага бүхий ажилтантай болсон. И-гэснээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг эрчимжүүлж байна. Цаг үеийн мэдээ мэдээллийг 5 телевиз, 1С сайтаар мэдээлэн хүргэсэн. Байгууллагын үйл ажиллагааг албан ёсны https://pcsp.gov.mn цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээ, мэдээллийн самбар зэргээр сурталчлан нээлттэй байдлыг хангаж ажилласан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын олон нийтийн сүлжээн дэх https://www.facebook.com/pcsp.gov.mn фэйсбуук пэйж хаяг ажиллуулж байна (100 хувь)

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь 2021 онд авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зааврын дагуу “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-г боловсруулан, нийт 6 зорилтын хүрээнд нийт 13 арга хэмжээг тусган баталж, хэрэгжилтийг хангав.

Холбогдох нотлох баримт, хүснэгт, фотс зураг зэргийг <http://khutulbur.iias.mn> цахим системийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан”-ийн сан дахь тухайн арга хэмжээний тайлан тус бүрд файл хэлбэрээр хавсаргасан болно.

Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн:

Төлөвлөсөн нийт арга хэмжээ – 13; Үүнээс:

- “Үр дүнтэй” буюу 100 хувь хэрэгжсэн арга хэмжээ – 12;
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай хэрэгжих шаганд байгаа арга хэмжээ – 1;
- “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30 хувийн хэрэгжилт бүхий арга хэмжээ – 0;
- “Үр дүнгүй” буюу 0 хувь, хэрэгжээгүй, тасарсан – 0;
- “Үнэлэх боломжгүй” буюу өөрсдөөс хамаарахгүй байгаа арга хэмжээ – 0;

Хэрэгжилтийн дундаж хувь, үнэлгээ – 97.8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ДЭД ДАРГА

А.АРИУНБОЛД

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

Боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны
2021 оны тайлангийн хавсралт № 1

НЭГ. "АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ"
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Хавсралт №1.1.

№	Хэрэгжүүлсэн байдал	
Арга хэмжээ №1.1.	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх	
Албан ёсны цахим хуудас	Вэб хаяг	https://pcsp.gov.mn
	Контентийн тоо	Нийтэлсэн - 6 мэдээлэл,
	Дагтамжийн тоо	Нийт хандалтын тоо - Байнга байршуулсан.
Нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube)	Сүлжээний нэр	Нийт – 2 сүлжээ: https://www.facebook.com/pcsp.gov.mn ; youtube
	Контентийн тоо	Реклам – 5 ш,
	Дагтамжийн тоо	Нийт өдрийн тоо - байнга
	Зарцуулсан хөрөнгө	-
	Санамж:	Байгуулсан гэрээ, зураг, бичлэг зэрэг нотлох баримтуудыг заавал файлаар хавсаргана.
Сурталчилгааны самбар	Сувгуудын нэр	Нийт - 4 самбар, Самбарын байршил: байгууллагын дотор
	Контентийн тоо	Нийт контентийн тоо – 5 ш
	Дагтамжийн тоо	Самбар байршуулсан нийт өдрийн тоо – жилийн турш
	Зарцуулсан хөрөнгө	-
	Санамж:	Зураг зэрэг нотлох баримтуудыг хавсаргаа
Бусад	Шалгуур үзүүлэлт	<ol style="list-style-type: none"> Бэлэн ном, товхимлын тавиур – 2 ш. Тавиурыг байнга буюу жилийн турш ажиллуулж, мэдээлэл түгээсэн. Стэнд 1 ш. Стэндийг 2020 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргах үеэр 2021.01.01-2021.02.15-ны өдрүүдэд мэдүүлэг гаргагчдад зориулан хуулийн заалт сурталчилсан.

Хавсралт №1.2.

№	Хэрэгжүүлсэн байдал		
Арга хэмжээ №1.2.	АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах		
АТГ-аас зохион байгуулсан аян, арга хэмжээ №1.	Салбар, орон нутгийн хэмжээнд аян зохион байгуулсан эсэх	Тийм	
	Зохион байгуулсан аяны тухай	<p>Аяны нэр: Гомдол, мэдээлэл хүлээн авах утас 110</p> <p>Уриа: Ил тод байдлыг эрхэмлэе.</p> <p>Зорилго: Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, албан хаагчдыг сэдэлжүүлэх</p>	
	Тус аяны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний нэр, төрөл	Хамрагдсан хүний тоо, авсан хандалтын тоо	Зарцуулсан хөрөнгө
	Арга хэмжээ №2.1. АТГ-т шударга бус байдлыг мэдээлэх үнэ төлбөргүй утас 110-ыг сурталчлах	6.2 мянга <	-
	НИЙТ	6.2 мянга <	-
	Гарсан үр дүн	<p>Үр дүн №2.1. Утсыг олон нийт мэддэг болсон.</p> <p>Үр дүн №2.2. Албан хаагчид зөрчил, доголдол гаргахгүй байх ойлголт авсан, хариуцлага өндөржсөн.</p>	
Санамж:	Зургаар нотолж харуулан хавсаргаа.		

Хавсралт №1.3.

№	Хэрэгжүүлсэн байдал						
Арга хэмжээ №1.3.	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах						
Мэдээллийн самбарыг шинэчилсэн мэдээллийн тоо, зарцуулсан хөрөнгийг доорх хүснэгтийн нүдэнд бөглөнө үү.							
Сар	Булан №1.	Булан №2.	Булан №3.	Булан №4.	Булан №5.	Нийт	Зарцуулсан хөрөнгө
2021 оны 1-р сар	-	-	-	-	-	-	-
НИЙТ: Уг самбарыг ТӨБЗГ-ын нэр дээр АТГ-аас өгөөгүй болно.							
Санамж:	Мэдээллийн самбарт сар бүрийн байршуулсан мэдээллүүдийг нэгтгэж, нэг pdf файл болгоно. 12 ширхэг pdf файл, сар бүр авсан 12 зургийг заавал файлаар хавсаргана.						

ХОЁР. "АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, АЛБАН ХААГЧДЫГ СУРГАЛТАД ХАМРУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Хавсралт №2.1. (Салбарын хувьд)

№	Хэрэгжүүлсэн байдал				
Арга хэмжээ №2.1.	Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-т хүргүүлж, албан хаагчдаа холбогдох сургалтад хамруулсан байх				
Үзүүлэлт	ТӨБЗГ	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын ажилтнууд	Орон нутгийн нэгжүүдийн ажилтнууд	Иргэд, бусад	Нийт
Сургалт, арга хэмжээний тоо	2		2
Хамрагдсан хүний тоо (давхардсан тоогоор)	2	2
Сургалтын сэдвийн тоо	Захиргааны дарга нарын сургалт, Хуулийн мэргэжилтний сургалт	2
Хамтран зохион байгуулсан байгууллагын тоо	АТГ
Зарцуулсан хөрөнгө	-
Санамж:	Холбогдох нотлох баримтыг файлаар хавсаргаав. Мөн АТГ-т хүргүүлсэн захиалгын мэдээллийг файлаар хавсаргаав.				

Хавсралт №2.2.а.

№	Хэрэгжүүлсэн байдал			
Арга хэмжээ №2.2.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байдал:			
Үзүүлэлт	Сургалт, арга хэмжээний тоо	Хамрагдсан хүний тоо (давхардсан тоогоор)	Зарцуулсан хөрөнгө	
Сургалт / Авлигын эсрэг /	5	90<	-	
Мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээ / Авлигын эсрэг хууль тогтоомж сурталчлах, соён гэгээрүүлэх чиглэлээр /	4 (мэдээллийн самбар, дотоод сүлжээгээр хүргэсэн мэдээлэл, сурталчилгааг тооцов)	100<	-	
Хэлэлцүүлэг зохион байгуулсан / Авлигаас урьдчилан сэргийлэх асуудлаар /	2	45	-	

Хурал, зөвлөгөөн зохион байгуулсан / Авлигаас урьдчилан сэргийлэх асуудлаар /	-	-	-
Сонсгол зохион байгуулсан / Авлигаас урьдчилан сэргийлэх асуудлаар /	-	-	-
Бусад хэлбэрээр хууль тогтоомж, сурталчилгаа үйл ажиллагаа зохион байгуулсан	Давхар ажил эрхлэлтийн судалгаа, мэдүүлээ үнэн зөв, хуулийн хугацаанд гаргах асуудлаар стэнд бэлтгэж байршуулсан.		55
Санамж:	Холбогдох материалууд, зургийг файлаар хавсаргаав		

Хавсралт №2.2.6.

№	Хэрэгжүүлсэн байдал		
Арга хэмжээ №2.2.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сургагч багшаар дамжуулан зохион байгуулсан байдал:		
Сургагч багшаар бэлтгэгдсэн хүний тоо	2 (Эрх зүйн сургалт, сурталчилгааны хү)		
Үзүүлэлт	Сургалт / арга хэмжээний сэдвийн тоо	Хамрагдсан хүний тоо (давхардсан тоо)	Зарцуулсан хөрөнгө
Сургагч багш нарын зохион байгуулсан сургалт, сурталчилгааны арга хэмжээ №1.	4 (ТӨБЗГ-ын албан хаагчдад)	80	-
Сургагч багш нарын зохион байгуулсан сургалт, сурталчилгааны арга хэмжээ №2.	1 ("Говь-Алтай АЗЗА" ТӨХК, "Увс АЗЗА" ТӨХК, "Ховд АЗЗА" ТӨХК-ийн удирдлага, зарим албан хаагчдыг оролцуулсан цахим сургалт)	10	-
Сургагч багш нарын зохион байгуулсан сургалт, сурталчилгааны арга хэмжээ №3.
Санамж:	Сургалтын холбогдох баримт, материалын зургийг файлаар хавсаргаав.		

ГУРАВ. "АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Хавсралт №3.1.

№	Хэрэгжүүлсэн байдал										
Арга хэмжээ №3.1.	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх										
Зөвлөмжийн нэр, дугаар	Тайлагнасан байдал			Арга хэмжээний тоо			Хэрэгжилт				Дундаж хувь
	Хариу ирүүлсэн	Хугацаанд нь хариу ирүүлсэн	Хариу ирүүлээгүй	Нийт	Дагтагдах шинжтэй	Нэг удаагийн шинжтэй	100%	70%	30%	0%	
Зөвлөмж №1. Хууль хэрэгжүүлэх тухай АТГ: 2021.05.12, № 06/5213	ТӨБЗГ: 2021.09.30, А-1/1562	тийм	хариу хүргүүлсэн								
Зөвлөмж №2. Хуулийн хэрэгжил-тийг хангуулах тухай АТГ: 2021.10.28, № 01/11458	ЗГХЭГ: 2021 он, ХЭГ/2690	тийм	хариу хүргүүлсэн								

Зөвлөмж №3. Зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай АТГ: 2021.12.03, № 01/13060	ТӨБЗГ: 2021.12.31, А-1/2228	тийм	хариу хүргүүлсэн	7	6	1	7	70
Зөвлөмж №4. 2022 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн бэлтгэл ажил ажлыг хангах тухай АТГ: 2021.12.17, № 01/13838	ТӨБЗГ: 2022.01.10, А-1/51	тийм	Хэрэг-жилтийг хангуулсан, хариу хүргүүлсэн.	8		8	8	100

Хавсралт №3.2.

№	Хэрэгжүүлсэн байдал								
Арга хэмжээ №3.2.	Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх								
Мэдэгдлийн нэр, дугаар	Тайлагнасан байдал			Арга хэмжээний тоо	Хэрэгжилт				Дундаж хувь
	Хариу ирүүлсэн	Хугацаанд нь хариу ирүүлсэн	Хариу ирүүлээгүй		100%	70%	30%	0%	
Мэдэгдэл №1. Мэдэгдэл хүргүүлэх тухай АТГ: 2020.12.09, № 90 (АТГ-ын 2021.10.20-ны өдрийн “хуулбар үнэн” дардастай)	ТӨБЗГ: 2021.10.21, А-1/1713	тийм	хариу хүргүүлсэн	2	2			100	
Мэдэгдэл №2. 01 дугаартай мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлэх тухай АТГ: 2021.12.23, № 06/13971	үгүй	Хугацаа болоогүй байгаа	Хүлээгдэж байна. 2022.01.23-ны өдөр хугацаа дуусна.	5				Хугацаа болоогүй.	

Хавсралт №3.3.

№	Хэрэгжүүлсэн байдал								
Арга хэмжээ №3.3.	Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх								
Мэдэгдлийн нэр, дугаар	Тайлагнасан байдал			Арга хэмжээний тоо	Хэрэгжилт				Дундаж хувь
	Хариу ирүүлсэн	Хугацаанд нь хариу ирүүлсэн	Хариу ирүүлээгүй		100%	70%	30%	0%	
Мэдэгдэл №1. Төрд учирсан хохирол барагдуулах тухай АТГ: 2021.03.18, № 06/3111	ТӨБЗГ: 2021 оны тогтоол № 395	Тийм	хариу хүргүүлсэн	1	1			100	
